



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 10 сарын 29 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

УЛСЫН ТЭМДЭГГИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/40² дугаар зүйл:

“40² дугаар зүйл.Таримал ургамлын сортын бүтээгчийн эрх олгох, эрхийг хүчинтэй байлгахад хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

40².1.Таримал ургамлын сортын бүтээгчийн эрх олгох, эрхийг хүчинтэй байлгахад доор дурдсан хэмжээгээр хураамж хураана:

40².1.1.сортын бүтээгчийн эрх олгоход 20 000 төгрөг;

40².1.2.сортын бүтээгчийн эрхийг хүчинтэй байлгахад жил бүр 60 000 төгрөг.”

2/5 дугаар зүйлийн 5.1.50 дахь заалт:

“5.1.50.Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан үйлчилгээ.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Таримал ургамлын үр, сортын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР